



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус: 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.09 № 01/1479
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Б.БАТЦОГТ ТАНАА

Хандивын тайлангийн дүгнэлт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Бүрэнтогтох сумын Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай Хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Бүрэнтогтох сумын Монгол ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол ардын намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ӨРДЭНЭБААТАР

8724041033



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын ... -ны
өдрийн дугаартай албан бичгийн хоёрдугаар
хавсралт

Маягт №-2

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

Нам, эвслийн нэр: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Монгол ардын намын хороо

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл						Хандив хүлээн авсан			АНСДИТХ-н сонгуулийн тухай хуулийн 53.4-т заасан хандивын мэдээллийн шавардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн эсэх				Тайлбар	
		Регистрийн дугаар	Хандивын эх үүсвэрийн мэдээлэл	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр	Дансны дугаар	Мөнгөн дүн	Тийм бол мөнгөн дүн	Хандивыг буцаасан дансны дугаар	Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлсэн тохиолдолд огноо, дансны дугаар бичих		
1																
2																
...																
	Дүн															
2023 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаа																
1																
2																
...																
	Дүн															
2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаа																
1																
2																
...																
	Дүн															
	Нийт дүн															

--00000--